



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2018 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 09

Шивээговь сум

Сумын 2019 оны төсөв батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 "б", 25-р зүйлийн 25.1, Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018.12.05-ны өдрийн №10 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. 2017 оны орон нутгийн төсвийн орлогыг **2 165 551.0** мянган төгрөгөөр, зарлагыг **2 138 551.2** мянган төгрөгөөр, үүнээс Орон нутгийн хөгжлийн сангийн зарлагын гүйцэтгэлийг 160 496,0 мянган төгрөгөөр тус тус баталсугай.

Хоёр. Сумын 2019 оны төсвийн орлогын нийт дүн, орлогын нэр төрлийн хэмжээг дор дурдсанаар баталсугай.

		/мянган төгрөг/
	Сумын төсвийн орлого бүгд	2 705 852.5
1	Урсгал орлого	56 836,7
1.1	Татварын орлого	56 836,7
1.1.1	Суутгагчийн ХХ-д олгосон ОАТатвар	15 000,0
1.1.2	Үйл ажиллагааны орлого	6 714,0
1.1.3	Бууны албан татвар	870,0
1.1.4	Улсын тэмдэгтийн хураамж	1 100,0
1.1.5	Хогны төлбөр	22 440,0
1.1.6	Хадгаламжийн хүүгийн орлого	10 712,7
2	Аймгийн төсвөөс авах шилжүүлэгийн дүн	2 549 656.9
2.1	Аймгийн төсвөөс авах сан/дэмжлэг	715 047,1
2.2	Тусгай зориулалтын шилжүүлэг	1 667 275,4
2.3	ТЗШ ЭМД-ийн сангаас санхүүжих	34 875,4
2.4	ОНХС-ийн орлогын шилжүүлэг	132 459,0
3	Тусгай сангууд	61 428,0
3.1	Сум хөгжүүлэх сан	61 428,0
4.	2017 оны тэнцлийн ашиг	16 224,9
5.	2018 оны ОНХС-ийн хэмнэлт	21 706,0

Гурав. Сумын 2019 оны орон нутгийн төсвийн зарлагын нийт дүн, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн жилд зарцуулах зарлагын дээд хэмжээг дор дурьдсанаар баталсугай.

/мянган төгрөг/

1	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга	54570,3
1.1	Урсгал зардлын дээд хэмжээ	54570,3
2	Засаг дарга	395395,3
2.1	Засаг даргын тамгын газар	395395,3
2.2	Соёлын төв	90 676,2
2.3	ЕБС-ийн тогтмол зардал	137 517,4
2.4	СӨББ-ын тогтмол зардал	33653,40
2.5	ЭМТ-ийн тогтмол зардал	69128,4
2.6	Орон нутгийн хөгжил сангаар хийгдэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ	161 332,7

Дөрөв. Тусгай зориулалтын шилжүүлэгээр санхүүжих төсөвт байгууллагын зардлын хэмжээг дор дурдсанаар баталсугай.

/мянган төгрөг/

3	Тусгай зориулалтын шилжүүлэгийн нийт дүн	1 702 150,8
3.1	ТЗШ СӨББайгууллага	454 388,7
3.2	ТЗШ ЕБСургууль	900 714,2
3.3	Эрүүл мэндийн төв	347047,9
4	Тусгай сан	61 428,0

Тав . Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын 2019 оны төсвийн жилд зарцуулах төсвийн зарлагын хэмжээг **2 705 852,5** мянган төгрөгөөр баталсугай.

Зургаа. Шивээговь сумын 2019 оны төсвийн жилд орон нутгийн хөгжил сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний зардлын дээд хэмжээг **161 332,7** мянган төгрөгөөр баталсугай.

Долоо. Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнг хавсралт 1-ээр баталсугай.

Найм. Орон нутгийн хөгжил сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний жагсаалтыг 2 дугаар хавсралтаар баталсугай.

Ес. Төсвийн тухай хуулийн 41-р зүйлийг баримтлан орон нутгийн төсвийн тэнцлийг бүрэн хангаж, хэрэгжилтийг зохион байгуулан, төсвийн орлогыг цаг хугацаанд бүрдүүлж зарцуулалтанд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргад даалгасугай.

Арав. Төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулж, санхүү төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байхыг төсвийн захирагч нарт үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.ЭРДЭНЭБАТ



Сумын ИТХ-ын 2018.12.17-ны ээлжит 19-р
хуралдааны 09 дүгээр тогтоолын
1 дүгээр хавсралт

**ТӨСВИЙН ЭРХ ЗАХИРАГЧ НАРЫН ХЭРЭГЖҮҮЛЭХ
ХӨТӨЛБӨР, ХҮРЭХ ҮР ДҮН**

Д/д	Төсвийн эрх захирагчийн нэр, тэдгээрийн хэрэгжүүлэх хөтөлбөр	Зорилтот түвшин		Зарцуулах төсөв / сая.төг/
		Чанар	Тоо	
1.	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга			54 570,3
1.1	ИТХ-ын үйл ажиллагаа	МУ-ын 33НДНТУТХууль болон төсвийн тухай хуульд заасан ИТХ-ын чиг үүргийг цаг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлэх	Сумын ИТХ-ыг жилд 3-4 удаа тэргүүлэгчдийн хурлыг 10-15 удаа хийх	54 570,3
2	Засаг дарга			
2.1 Орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ				
2.1.1	Засаг даргын ажлын алба	Сумын эдийн засгийн чадавхи сайжирч, төрийн үйлчилгээний чанар хүртээмж сайжирна.	Төсвийн орлогыг 100-аас доошгүй хувиар биелүүлнэ.	367 613,3
2.1.2	Багийн засаг даргын үйл ажиллагаа	МУ-ын 33НДНТУТХууль болон төсвийн тухай хуульд заасан ИТХ-ын чиг үүргийг цаг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлэх	Багийн ИНХ-ыг жилд 3-4 удаа зохион байгуулна.	27 782,0
2.2 Тусгай зориулалтын шилжүүлэгээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ				
2.2.1	Сургуулийн өмнөх боловсрол			488 042,1
2.2.1.1	Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ	Цэцэрлэгийн хамран сургалт 100 хувь, сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 100 хувьд хүргэнэ.	Цэцэрлэгт нийт 286 хүүхэд хамрагдана.	488 042,1

2.2.2	Ерөнхий боловсролын үйлчилгээ			997 305,4
2.2.2.1	Ерөнхий боловсролын үйлчилгээ	Суурь болосролын хамран сургалт 90 хувьд хүргэнэ	Ерөнхий болосролын сургуульд 540 хүүхэд суралцана.	997 305,4
2.2.3	Соёлын үйлчилгээ			90 672,2
2.2.3.1	Соёлын үйлчилгээ	Иргэдэд үзүүлэх соёл, урлагийн үйлчилгээний хүртээмж нэмэгдэнэ. Номын сангийн фонд баяжилт сайжирч, үйлчилгээний хүртээмж нэмэгдэнэ.	Сумын соёл урлагаар үйлчлүүлэх хүний тоо 1500, номын сангаар үйлчлэгчдийн тоо 500	90 676,2
2.2.4	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ			416 176,3
2.2.4.1	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ			416 176,3

**Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын Орон нутгийн хөгжлийн сангийн
хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний
жагсаалт**

(мян.төгрөг)

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх, дуусах хугацаа	Төсөвт өртөг	2019 онд шилжүүлэх дүн
1. Шинээр эхлэх хөрөнгө оруулалт		2019	133500,0	133500,0
Ажил /их засвар/				
1.1.	Нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлгийн урсгал засварын зардал	2019	15000,0	15000,0
1.2.	3-р цэцэрлэгийн барилгын сантехникийн засварын ажлыг хийх	2019	8000,0	8000,0
1.3.	Төв талбайг тохижуулах, усан оргилуур байгуулах	2019	50000,0	50000,0
Бараа /тоног төхөөрөмж/				
1.4.	Орон нутгийн өмчид шинээр өмч бий болгох /Сургуулийн ширээ сандал худалдан авах/	2019	10000,0	10000,0
1.5.	Үүрдэг хогийн савыг нэмэгдүүлэх	2019	5000,0	5000,0
1.6.	Орон нутгийн өмчид шинээр өмч бий болгох /Мэдээллийн хэрэгсэл худалдан авах/	2019	5000,0	5000,0
Зөвлөх үйлчилгээ				
1.7.	Зөвлөх үйлчилгээ	2019	40500,0	40500,0
2. ОНХС-аас санхүүжих суурь зардал				27832,7
Хөтөлбөр /төсөл арга хэмжээ/				
2.1.	Сумын "Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих" дэд хөтөлбөр, "Хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих" дэд хөтөлбөр	2019	11000,0	11000,0
2.2.	Баяр наадмын зардал	2019	5000,0	5000,0
2.3.	Мал амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж золбин нохой муур устгах, хяналт тавих	2019	2500,0	2500,0
2.4.	Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн усалгаа арчилгааг сайжруулах, тохижилт хийх	2019	3,332,7	3332,7
2.5.	Гамшгаас хамгаалах зардал	2019	6000,0	6000,0
НИЙТ				161332,7